



## МОНГОЛЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООНЫ ГИШҮҮНИЙ ТАТВАРЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам МЗХ-ны үндсэн дүрмийн хүрээнд гишүүний татварын харилцааг зохицуулна.
- 1.2 Гишүүнээс авсан татвар нь МЗХ-ны үйл ажиллагаанд оролцох хариуцлагыг нэмэгдүүлж, салбар нэгж, байгууллагуудыг санхүүгийн хувьд бэхжүүлэхэд чиглэгдсэн байвал зохино.

### Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 МЗХ-ны гишүүний татварыг идэвхтэн, сонгуульт гишүүний татвар гэж тус тус ангилна.
- 2.2 Идэвхтэн, сонгуульт гишүүний татварын хэмжээ, төлөх хугацааг Их Хурал /ИХ/ тогтооно. Шаардлагатай үед тухайн жилийн онцлог, нөхцөл байдлаас хамааран татварын журам, татварын хэмжээ, төлөх хугацааг Удирдах Зөвлөл /УЗ/ шинэчлэн тогтоож болно.
- 2.3 Гишүүний татварыг МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүд төлөх үүрэгтэй.
- 2.4 Гишүүний татвар төлөлтийн тайланг МЗХ-ны хувьд ХЗ, УЗ-д тус бүр нэг, нэг хувийг жилд нэг удаа танилцуулна. Бусад шатны залуучуудын байгууллагын хувьд тухайн шатны залуучуудын байгууллагын Хяналтын зөвлөл, дээд шатны залуучуудын байгууллагын УЗ-д тус бүр нэг хувийг хагас жилд нэг удаа танилцуулна.

### Гурав. Гишүүний татварыг хураах, бүртгэх

- 3.1 МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүн харьяалагдах тухайн шатны залуучуудын байгууллагад тогтоосон хэмжээний татварыг хугацаанд нь төлөх үүрэгтэй.
- 3.2 МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүд нь жилийн татвараа тухай оны 2-р сарын 1-ны дотор төлнө.
- 3.3 Байгууллагын дансанд тушааж, идэвхтэн, сонгуульт гишүүний үнэмлэх дээр тэмдэглэгээ хийж, цахим бүртгэлд оруулна.

### Дөрөв. Сонгуульт гишүүний татвар

- 4.1 Бүтцийн бүх шатны залуучуудын байгууллагын залуучуудын зөвлөл, УЗ, ҮЗЗ-ийн гишүүний татваруудыг сонгуульт гишүүний татвар гэнэ.

Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 12-ний өдрийн 25 хурлын 25 тоот тогтоолын хавсралт № 1.



4.2 Сонгуульт гишүүн нь жилийн татвараа харьяалагдах шатны залуучуудын байгууллагын дансанд 2-р сарын 1-ний өдрийн дотор төлнө. Татвараа төлсөн гишүүн ротацид орсон тохиолдолд тухайн жилийн татвар нь дэнчинд тооцогдоно.

4.3 Тухайн жилийн ротацийн сонгууль дуустал МЗХ-ны бүтцийн бүх шатны залуучуудын байгууллагууд ДЭНЧИНГ захиран зарцуулах эрхгүй.

4.4 Тухайн жилийн ротацийн сонгуулийн дараа сонгогдсон гишүүний дэнчин нь тухайн жилийн татварт тооцогдон үлдэнэ. Ротацийн сонгуулиар сонгуульт үүргээсээ чөлөөлөгдсөн гишүүн дэнчингээ буцаан авах эрхтэй.

#### **Тав. Татвар төлөөгүй гишүүнд хүлээлгэх хариуцлага**

5.1 МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүн нь татвараа төлөөгүй бол тухайн шатны хуралд саналын эрхгүй оролцоно.

5.2 Сонгуульт гишүүн нь татвараа төлөөгүй бол сонгуульт үүргээсээ чөлөөлөгдөн, суудал дээр нь нөхөн сонгууль явагдана.

5.3 ИХ, УЗ-с тогтоосон хэмжээний татварыг төлөөгүй гишүүнд урьдчилан сануулсны үндсэн дээр МЗХ-ны сонгуульт албан үүргээс чөлөөлөх болон саналын эрхийг нь хасах тухай шийдвэрийг тухайн шатны залуучуудын байгууллагад гаргана.

#### **Зургаа. Бусад**

6.1 МЗХ-ны идэвхтэн, сонгуульт гишүүн тогтоосон хугацаанд дараах татварыг төлнө. Үүнд: 1 жилээр тооцов.

Д/д	Гишүүн	Татварын хэмжээ
1	Идэвхтэн гишүүний суурь татвар	20,000₮
2	Байгууллагын 33-ийн тэргүүлэгч гишүүд	48,000₮
3	Байгууллагын 33-ийн тэргүүн	60,000₮
4	Баг, хэсгийн Залуучуудын зөвлөлийн тэргүүн, тэргүүлэгч гишүүд	36,000₮
5	Сум, хорооны Салбар Холбоодын тэргүүн, тэргүүлэгч гишүүд	48,000₮

Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын  
18-ний өдрийн хурлын 08 тоот тогтоолын  
хавсралт № 1



6	УБ хот дахь Салбар Холбоодын тэргүүлэгч гишүүд	120,000₮
7	УБ хот дахь Салбар Холбооны тэргүүн	240,000₮
8	Гадаад улс дахь салбар ЗХ-ны тэргүүлэгч гишүүд	120,000₮
3	Гадаад улс дахь салбар ЗХ-ны тэргүүн	120,000₮
10	Аймаг, дүүргийн Салбар Холбооны тэргүүлэгч гишүүд	120,000₮
11	Аймаг, дүүргийн Салбар Холбооны тэргүүн	240,000₮
12	Аймаг, дүүргийн бага чуулганы гишүүн	60,000₮
13	Чиглэлийн ЗХ-ны тэргүүлэгч гишүүн	120,000₮
14	Чиглэлийн ЗХ-ны тэргүүн	240,000₮
15	ҮЗЗ-ийн чөлөөт суудлын гишүүд	360,000₮
16	Байнгын хорооны тэргүүлэгч гишүүд	120,000₮
17	МЗХ-ны Удирдах зөвлөлийн гишүүд	2,000,000₮
18	МЗХ-ны Ерөнхийлөгч	3,000,000₮